

19 Эмнэлгийн хог хаягдал

Энэ бүлэгт

Хуудас

Эмнэлгийн хог хаягдлаас үүдэх эрүүл мэндийн асуудал	420
Түүх: Сангүүд тохиолдсон явдал	421
Хог шатаахаас үүдэх асуудлууд	423
Эрүүл мэндийн хог хаягдлаас урьдчилан сэргийлэх	424
Хог хаягдлыг багасгах	425
Хогийг ялга	426
Хогийг хадгалж гэвэрлэх	427
Хог хаягдалтай ажиллах үед гарах аюул гэмтлээс урьдчилан сэргийлэх:	428
Хогийг халдваргүйжүүлэх	429
Химийн бодисоор халдваргүйжүүлэх	430
Хлорын шохой ашиглан халдваргүйжүүлэх нь	432
Дулаанаар халдваргүйжүүлэх нь	434
Халдвартай хог хаягдлыг хаях	436
Вакцинжуулалтын хөтөлбөрүүд.....	437
Эрүүл мэндийн хог хаягдлыг булах	438
Химийн хог хаягдлыг аюулгүй аргаар хаях	440
Дасгал: Эрүүл мэндийн хог хаягдлын нөхцөл байдлын үнэлгээ хий	443
Орон нутгийн хамтын шийдэл	447



Эрүүл мэндийн ажилтнууд хүний эрүүл мэндийг хамгаалахын тулд маш их ажилладаг. Гэхдээ эрүүл мэндийн газруудын хог хаягдлыг зөв хаяхгүй бол энэ нь эрүүл мэндийн ажилтнуудад өвчин тараах ба эргэн тойрны орчинд аюултай болдог. Эрүүл мэндийн газруудын хог хаягдал нь эмнэлэг, амбулатори, лаборатори, цусны банк, шүдний эмнэлэг, мал эмнэлэг болон амаржих газруудын болон вакцинжуулалтын төсөл, эмнэлгийн тусламж үзүүлэх үйл явцын үеийн хог хаягдал байдаг юм.

Эмнэлгийн газрын жирийн хог хаягдлын ихэнх нь цаас картон, хоолны үлдэгдэл зэрэг хог байдаг. Гэхдээ зарим эрүүл мэндийн эмнэлгийн хог хаягдал нь аюултай нян өвчин агуулсан цус, биеийн шингэн зэргийг агуулсан хог байдаг юм. Ашигласан зүү, хурц үзүүртэй зүсдэг материалууд зэрэг нь хүнийг гэмтээх буюу өвчин тараах аюултай.

Шархны лент, шархны боодол зэрэг эмнэлгийн зарим хог хаягдлууд нь химийн хорт хаягдлыг агуулсан байдаг. Аюултай нян буюу химийн хортой бодис агуулсан хог хаягдлуудыг жирийн хог хаягдалтай холих юм бол холимог хог хаягдал нь тухайн хог хаягдлын орчинд байгаа бүх хүмүүст аюултай болдог.

Ийм учраас эмнэлэг дотор хогийг ялгах нь хамгийн чухал. Эмнэлгийн хог хаягдлыг аюулгүй болгохдоо хатуу хогийг аюулгүй болгох үндсэн зарчмуудыг ашиглана. Гэхдээ хүний биеийн шингэн буюу өвчний нян агуулсан хогийг ариутгаж, дараа нь хүн болон орчны эрүүл мэндэд аюулгүй байдлаар хаях хэрэгтэй.

Эмнэлгийн хог хаягдлаас үүдэх эрүүл мэндийн асуудал


Хэрэв буруу хаяж болгоомжгүй байлгасан бол бүх төрлийн хогноос эрүүл мэндийн асуудал үүснэ. Гэхдээ эрүүл мэндийн газраас гарсан хог нь илүү аюултай доорх асуудлыг үүсгэдэг юм:

- В,С төрлийн элэгний гепатит, татран өвчин, ДОХ болон арьсны янз бүрийн халдварт өвчнүүд, зүү болон хурц багажаас үүсэх шарх.
- Харшил, арьсны маажуур, нүдний загатнаа, астма болон бусад амьсгалын замаар янз бүрийн химийн бодис нэвтрэн өвчлөл үүсгэх.
- Антибиотикт тэсвэртэй болох. Хүн антибиотиктай олон дахин харьцаж, увал тухайн хүний биед байгаа нянгууд антибиотикт тэсвэртэй болж түүнд антибиотик үйлчлэхээ болино
- Хорт хавдар, амьсгалын замын өвчин болон хортой химийн хаягдал, диоксин зэрэг хог хаягдал шатаах үед үүсэх аюултай бодисоос удаан хугацааны өвчин тусна.


Эрүүл мэндийн хог хаягдлаас өвчин тусах магадлалтай хүмүүс:



Эмнэлгийн газруудаас хог цуглуулдаг, эмнэлгийн газрын хаягдлыг дахин ашигладаг, эмнэлгийн хогийг хогийн цэгт хүргэж өгдөг хүмүүс



Эмнэлгийн хог хаядаг газруудын ойролцоо амьдардаг хүмүүс



Эмнэлэгт байгаа ажилтан болон өвчтөн

Сангүүд тохиолдсон явдал

Сангүү охин энэтхэгийн нэгэн жижиг тосгонд төржээ. Олон жил ган гачиг болж ургац алдсаны дараа тэр ээж дүү хоёртойгоо хотод нүүж ирсэн байна. Тэр ээжтэйгээ, ээжийнхээ гэр бүлийнхний хамт хогийн цэгийн ойролцоо байдаг нэгэн эрэг дээр амьдарч байжээ. Тэр хавийн хүүхдүүд Сангүүд хог дээрээс юм олж зардаг тухай ярьж, үзүүлжээ.

Өглөө бүр сургуульдаа явахын өмнө тэр хог ухаж тэндээс лааз, шилэн лонх, гялгар уут болон бусад зүйлсийг олдог байжээ. Тэр олсон зүйлсээ зарсан мөнгөөрөө хичээлийнхээ үеэр хоол авч иддэг байв. Хотын амьдрал хүнд хэцүү байсан бөгөөд түүний ээж өдөр бүр гэрээсээ хол газар очиж ажилладаг байж. Сангүү өдөр болгон дүүгээ харсаар сүүлдээ сургуульдаа явахаа болив. Ингээд тэр өдөр бүр олон цагийг хог ялгах ажилд өнгөрүүлдэг болов.

Тэр хог руу очихдоо дүүгээ үүрээд явдаг байв. Заримдаа тэр цус болсон боодол, зүү зэрэг эмнэлгийн зүйл олдог байв. Түүний сандаал нимгэн тул хогон дундуур явахад нь хөлийг хатгаж металл шилэнд зүсүүлэх зэргээр шагай хөлөө нилээд шархдуулжээ. Нэг удаа тарианы зүү түүний сандаалыг нэвт хатган хөл рүү нь яваад орчихлоо.

Сангүү зүүгээр хатгуулснаас хойш халуурч, ядарч, хоолой нь хатах болжээ. Хэдэн сарын дараа гайгүй болсон ч дахиад л өвчин туслаа. Тэр үргэлж ядарч, халуурч, хоолой хатаж, турж эхэлсэн юм. Ээж нь түүнд санаа нь зовж байсан ч түүнийг эмчид үзүүлэх мөнгө байхгүй байлаа. Эцэст нь ээж нь хамаатнаасаа мөнгө зээлээд түүнийг эмнэлэгт аваачив. Сангүү болсон явдлыг ярихад цусны шинжилгээ аваад, маргааш нь ирэхэд түүнийг ДОХ туссан гэв. Тэгээд эм авах хэрэгтэй болсон ч түүнд ямар ч мөнгө байсангүй. Ээж нь Сангүүг эмчлэх мөнгө байхгүй болохоор охиноо авч харив. Сангүү ямар ч эмгүй халуурч хэвтдэг байв. Хүн бүхэн түүний эдгэхгүйг мэддэг байв. Тэр хэдэн сарын дараа нас барсан юм.




Сангүү яагаад нас барсан бэ?

Сангүү эмнэлгийн хэрэглэсэн тарианы зүүн дээр гишгэснийхээ дараа ДОХ-ын вирусээр халдварлажээ. Түүний өвчин болон үхэл нь эрүүл мэндийн хог хаягдлыг буруу хаясан байгаль орчны асуудлаас шалтгаалсан юм. Мөн ядуурал хэмээх нийгмийн асуудлаас шалтгаалжээ.

Сангүүгийн үхлийг хэрхэн урьдчилан сэргийлж болох байсан бэ?

Янз бүрийн нийгмийн асуудлууд ядууралд нөлөөлдөг учраас түүнийг тийм амархан шийдэж чаддаггүй юм. Доорх асуудлууд нь түүнтэй холбоотой янз бүрийн асуудлыг олж харуулна.

- Тэр яагаад сургуульд орж чадаагүй вэ?
- Сангүү яагаад хог ухах болсон бэ?
- Сангүү яагаад хөлөө хамгаалах сайн гуталтай байж чадаагүй вэ?
- Сангүү яагаад эмнэлгийн тусламж авч чадаагүй вэ?



Нимгэн гутал, эм авч эмнэлгийн тусламж авах мөнгөгүй байх, мөнгө олох аргаа барсан хүсэл шаардлага, хоол унд муутай байх энэ бүхэн нийлээд ядуурал бөгөөд түүний үхлийн шалтгааны хэсэг бүрэлдэхүүн юм. Ийм нийгмийн асуудлуудыг бүрэн шийдэх шийдэл олоход удаан хугацаа шаардагдана.



Эрүүл мэндийн хог хаягдал нь олон хүний амьдралд муугаар нөлөөлнө. Ялангуяа эмнэлгийн тусламж авч чадахгүй байгаа нэн ядуу хүмүүст хамгийн түрүүнд нөлөөлнө.

Хэдийгээр нийгмийн асуудлыг шийдэхэд удаан хугацаа шаарддаг ч байгаль орчны асуудлыг шийдэхэд богино хугацаа шаардлагатай ба шийдэхэд хялбар байдаг юм. Үүнийг эхлүүлэхийн тулд дараах асуултыг асууя:


- Аюултай эмнэлгийн хаягдал яагаад бусад, дахин ашиглаж болохуйц хог хаягдалтай нийлсэн байсан бэ?
- Яагаад их хэмжээний аюултай хог хаягдлыг газарт булахгүй ил хаясан байсан бэ?

Эрүүл мэндийн хог хаягдлыг хариуцлагатай хаях нь хүн бүхний амьдрах орчныг сайжруулдаг ба ялангуяа нийгмийн хамгийн эмзэг ядуу хэсгийг хамгаална.

Хог шатаахаас үүдэх асуудлууд

Эрүүл мэндийн хог хаягдал дотор байдаг нянг устгахын тулд олон эмнэлгүүд хогоо шатаах зууханд хийдэг. Эмнэлгийн хогийг шатаах нь хялбархан шийдэл юм шиг санагдана. Ердөө л хогийг ачиж ирээд зууханд хийх юм шиг байдаг. Гэвч энэ нь эрүүл мэндийг харин ч илүү дордуулдаг. Хогийг ил байна уу, зууханд байна уу шатаах нь химийн бодис гаргаж, тэр нь газарт унаж ус руу ордог.

Мөнгөн ус, хар тугалга болон хүнд металл ялгаруулдаг хогнууд шатах үед орчин тойрныг хордуулна. Жишээлбэл, дуслын тариа хийдэг гялгар хуванцарууд, цусны уут, цус, тарианы хоолой болон нэг удаагийн тариурууд шатаахад диоксин буюу фуран гэх аюултай химийн хор ялгаруулна. Эдгээр хорнууд нь өнгө үнэргүй бөгөөд хорт хавдар үүсгэж, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг үргүй болгож, олон янзын эрүүл мэндийн аюулыг үүсгэнэ. /16, 20-р бүлгийг үз/




Заримдаа шатаах зуухнууд нь хогийг удаан, сайн шатааж чаддаггүй учир хогийг бүрэн арилгадаггүй. Зарим шатаах зуухнууд нь зөвхөн нэг төрлийн хогийг шатаахад зориулсан байдаг. Гэвч тэр нэг төрлийнхөө зүйлийг шатаахгүй хортой зүйлүүдийг бас шатаадаг практикт шилждэг.

Эрүүл мэндийн хог хаягдлыг аюулгүй болгохын тулд хэрэглэх хамгийн анхны арга нь: дахин хэрэглэж болох хортой нян агуулсан материалуудыг халдваргүйжүүлэх хэрэгтэй. Мөн шатаах зуухны оронд бусад аюулгүй хог хаягдал арилгах аргыг хэрэглэж, эрүүл мэндийн ажилчдаа хүний эрүүл мэндийг хамгаалах тангарагт нь үнэнч байлгаж, хэцүү ч гэсэн зөв аргаар хогноос салахад нь туслах хэрэгтэй.

Эрүүл мэндийн хог хаягдлаас урьдчилан сэргийлэх

Эрүүл мэндийн жижиг эмнэлэг, том эмнэлэг буюу гэр орондоо эмнэлгийн багаж хэрэгслийг хэрэглэх үедээ аюулгүй ажиллагааг хангах хэрэгтэй.

- Эмнэлгийн тоноглол хэрэглээ болгоомжтой зөв сонгох замаар хог хаягдлынхаа хэмжээг багасга.
- Хог хаягдал гарч ирэх үед түүнийг ялгаж салга.
- Нянтай хог хаягдлыг ариутга.
- Химийн хог хаягдлыг саармагжуулж аюул багатай болго.
- Хогийг аюулгүй аргаар хадгалж тээвэрлэ.
- Эмнэлгийн хог хаягдлыг хамгийн аюулгүй аргаар хаяж устга.
- Эмнэлгийн хог хаягдлыг гаргаж арчилж байгаа хүн бүхэнд хог хаягдалтай харьцах талаар сургалт явуул.



Ямар аргаар эмнэлгийн үйлчилгээ явуулж байгаагаас үл хамааран бүх эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд, бүх хүмүүс эрүүл мэндийн хаягдалтай зөв харьцаж сурах, ялангуяа шинэ орсон хүмүүс эмнэлгийн хогийг яаж зөв ангилах талаар мэдэж авч дадлага хийх ёстой байдаг. Ихэвчлэн хүмүүс ажлынхаа байрыг илүү аюулгүй, орчноо хүмүүст хоргүй болгохын тулд шинэ санаануудыг гаргадаг. Зарим эмнэлгүүд хүмүүсийг бэлтгэж сургадаг байнгын багтай байдаг. /449-452-р хуудсыг үз/

Хог хаягдлыг багасгах

Цөөн болон бага хортой материал ашиглах замаар эмнэлгийн хог хаягдлыг багасгаж болно. Эмнэлэгт материал сонгож авахын өмнө түүнээс ямар хог гарахыг бодож үзэх хэрэгтэй. Тэр нь хэр зэрэг аюултай вэ, та яаж тэрийг хаях вэ гэж бод.

Аюултай хог хаягдлын хэмжээг багасгахдаа:

- Хэрэв дахин ашиглаж болох материалын сонголт байвал нэг удаа хэрэглээд хаядаг зүйлээс татгалзаж, дахин аюулгүй ашигладаг зүйлийг хэрэглэ. Гэхдээ тариурыг дахин ашиглаж болохгүй.
- Мөнгөн усгүй халууны шил ашигла. Мөнгөн усгүй халууны шил нь арай үнэтэй, илүү бат бэх, эвдэрсэн үед аюулгүй юм.
- Хэрэгцээнээсээ илүү хэмжээний эм бүү ав. Эмийг зөвхөн хэрэгцээнийхээ хирээр ашигла.
- Тариа авахын оронд эм хэрэглэ.
- Боломжтой газарт хуванцар бус зүйлийг хэрэглэ.
- Цэвэрлэгээндээ хамгийн бага хортой зүйлүүдийг хэрэглэ. Боломжтой газруудад ариутгалын аргуудыг ашигла.
- PVC оролцоогүй материалаар хийсэн дуслын шингэний уут, дуслын шингэний хоолой зэргийг хайж олж ав. Тэр материалууд хямд бөгөөд орчин тойрон болон өвчтөнд хор багатай.



Хорыг ялга

Эрүүл мэндийн хог хаягдлыг заавал ялгаж салгаж хаях ёстой. Хог ялгах нь эрүүлийг хамгаалах нэгэн чухал үе шат юм. Хогийг ялгах нь эрүүл мэндийн ажилтнуудын болон хог хаягдлыг цуглуулж худалддаг, дахин боловсруулдаг хүмүүсийн эрүүл мэндэд учрах эрсдлийг эрс багасгана. Хогийг ялгаснаар булаах хог болон боловсруулах хогнуудын хэмжээ тус тус багасна. Мөн хог арчилгааны зардал хэмнэгдэнэ.



Эмнэлгээс гарсан хоолны хаягдлыг ялмаг болгон цэцэрлэгт хүрээлэнд ашиглаж болно.

Хог хаягдлыг өөр өөр өнгөтэй саванд ялгах


Олон эмнэлгийн газруудад хогийг хаяхдаа өөр өөр өнгөтэй саванд хийж хураадаг. Энэ аргыг зөв хэрэгжүүлэхийн тулд эмнэлэгт байгаа бүх хүмүүс ямар өнгөтэй саванд ямар хог хийхийгээ мэддэг байх ёстой.

Янз бүрийн орнууд хогны нэр төрөлд янз бүрийн өнгийн сав гаргадаг. Жишээлбэл, улаан өнгийн сав нь аюултай хог хаягдлын сав байдаг. Тиймээс тариурын зүү, хурц үзүүртэй зүйлс болон химийн хортой хагарсан шиллэг зүйлс гэх зэрэг хог хаягдлыг улаан өнгөтэй саванд хийдэг. Тэдгээр савыг заримыг нь улаан өнгөөр хийдэг ба улаанаар будаж тавьдаг. Эсвэл зарим дээр нь улаан скочоор бүслүүр хийсэн байдаг.


Гэхдээ эмнэлэгт гардаг хаягдлуудын талаас илүү нь гэрээс гардаг хогтой адил байдаг. Цаас, картон, шил лонх, лааз, хоолны үлдэгдэл зэрэг жирийн л хог гардаг. Эдгээр хогуюдыг аюултай хогноос ялгаснаар хогны менежмент хийхэд аюул багатай болдог.



Жирийн хогийг хогийн саванд доторх уутанд хийж, ялгаж, дахин ашиглах буюу хоёрдогч түүхий эдэд өгч, эсвэл ялзмаг болгож болно.



Аюултай хог хаягдлыг тусад нь өөр саванд хийж маш болгоомжтой хаях хэрэгтэй. /442-р хуудсанд байгаа хүснэгтийг үз/



Хогийн савуудыг:

- Хог гарч байгаа газарт ойр байрлуулах хэрэгтэй.
- Өнгө, тэмдгүүдээр тэмдэглэх хэрэгтэй.
- Асгарч гоожихооргүй хатуу, баг бөх саванд хийх ёстой.
- Асгарах, гоожих, эвдрэх эрсдэлгүйгээр тээвэрлэж, таглаж болохуйц байх ёстой.
- Бүтэн өдрийн хогийг хийхэд талаасаа илүүгүй хэмжээгээр дүүрдэг байхуйц хангалттай том сав байх ёстой.

Хогны уут, хогийн сав хоёр нь ижил өнгөтэй байвал тохиромжтой байдаг. Хэрэв хогны уутыг савтайгаа адил өнгөтэйгөөр тааруулах боломжгүй бол хогны уутнууд дээр будгаар юм уу скочоор хогийн савтай нь адил өнгөөр тэмдэглэл хийх хэрэгтэй. Уншиж бичиж чаддаггүй ажилтнуудад өнгөний ялгаагаар хогийн савны журмыг танилцуулах нь хялбар байдаг. Уншиж чаддаг хүн ямар хог нь аюултайг хараад л мэддэг байх нь хэрэгтэй.

Хогийг хадгалж тээвэрлэх

Эрүүл мэндийн хог хаягдлыг хогийн цэг рүү хүргэх хүртлээ маш болгоомжтой байх хэрэгтэй. Эрүүл мэндийн хог хаягдлууд нь хог хаягдал гарч байгаа газар байрлах ёстой ба тэр орчиндоо халдваргүйжүүлэгдэж байх ёстой. Харин эмнэлгийн хортой буюу халдвартай хогийн савыг коридор, угаалгын өрөө болон бусад өөр хогтой холилдож болохуйц газар тавьж болохгүй.

Хогийн сав болон хогийн уутыг 3/4 хүртэл хэмжээнд дүүрэхэд нь хааж битүүлж бай. Хогийн уутнууд нь 3/4 орчим дүүрэн байх үедээ урагдаж асгарах нь ховор байдаг. Энэ нь хогийг ялгаж авч байгаа ажилчдад гэмтэл учруулахаас хамгаална.

Ашигласан зүү болон бусад хурц үзүүртэй зүйлсийг гялгар уутанд хэзээ ч бүү хий /440-р хуудсыг үз/ Хэрэв уут гэмтэж цоорвол түүнийг өөр уутанд давхар хий. Хогийн уутыг ачиж авч явах хүртэл хаалттай түгжээтэй өрөөнд хогийг хадгал. Хог хадгалдаг өрөө нь хог цуглуулдаг хүмүүс орохооргүй сайн хамгаалагдсан байх ёстой.

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг аюулгүй аргаар хурдан хурдан зөөж хаях хэрэгтэй. Хогон дотор байгаа халдвар задарч муудаж эхлэнгүүт муухай үнэр үнэртэж, орчинд халдвар тарах аюултай байдаг тул хогийг өдөрт нь хаявал зохино. Хогийг гурав хоногоос илүү бүү хадгал. Хогийг хэт удаан хадгалсныг таны хамар андахгүй мэдэх болно. Хогийг цэвэрлэж, хог хаягдлын төв рүү хүргэхдээ дугуйтай түрдэг тэрэг, чиргүүлүүдийг ашигла. Тэдгээрийг ашигласныхаа дараа заавал угааж бай.

Мөн тэрэгнүүд нь хогийн уутыг урахааргүй, урж цоолохооргүй хурц үзүүртэй өнцөг булангүй байх ёстой. Ачиж буулгах үед тэргэнд хогийн уут урагдахааргүй байх ёстой.

Хог хаягдалтай ажиллах үед гарах аюул гэмтлээс урьдчилан сэргийлэх:

- Тариурын зүү болон бусад хурц үзүүртэй зүйлс, өвчний нян, цус болон бусад химийн шингэн бодис үсрэхээс хамгаалж хамгаалалтын хувцас өмс.
 - Тариурын зүүг хэрэглэнгүүтээ зүү болон хурц үзүүртэй зүйлийг хадгалах хогийн саванд хий. Хурц үзүүртэй зүйл болон зүүг уутанд бүү хий. Хогонд гар хүрснийхээ дараа болон өвчтөнтэй ажиллахын өмнө буюу дараа үргэлж гараа угаа.
 - Тариурын зүүг таггүйгээр авч явж болохгүй.
 - Хог хаягдлыг арьсандаа бүү хүргэ. Хэрэв хортой хог хаягдлын чийгнээс хувцас норвол түүнийг яаралтай тайлж биеэ их савантай усаар угаа.
 - Хамгаалах хувцас нь зөвхөн цэвэрхэн үедээ л хамгаалалт болж чадна.
- Ээлжинд гарсныхаа дараа өөрийн өмсдөг хувцас, зүүдэг нүдний шил, амны маск зэргээ угааж ариутга. /434-р хуудсыг үз/ Энэ нь хамгаалалтын хувцсыг өмсөж буй дараагийн ээлжийн хүнийг хамгаалах болно.



Хэрэв таны ажилладаг эмнэлэгт хамгаалалтын хувцас байхгүй бол гарын доорх

материал ашиглан өөрийгөө хамгаал. Жишээлбэл, хогны том гялгар уут нь хамгаалалтын халат өмд маск болон малгай болж болно. Бага зэргийн хамгаалалт нь огт хамгаалалтгүй байснаас ямагт дээр байдаг.

Хогийг халдваргүйжүүлэх

Халдваргүйжүүлэлт хийх гэдэг нь халдвар тараадаг нянг устгах гэсэн үг юм. Эмнэлгийн газрууд халдвар үүсч тарж байгаа газруудад халдвар тарах боломжтой зүйлсийг аль болох халдваргүйжүүлэх ёстой. Ингэхдээ халдвар гарч байгаа газар нь арга хэмжээ авах нь сайн.

Хамгийн эрүүл халдваргүйжүүлэлтийн арга нь: хлорин цайруулагч пироксид буюу химийн бодис ашиглах, буцалгах, ууранд халаах, даралттай ууранд халаах, микропеч болон автоклер зууханд халдваргүйжүүлэлт хийнэ. Хог хаягдлыг халдваргүйжүүлсний дараа түүнийг тайван булж, хаяж болно.

Халдваргүйжүүлэлт ариутгал хоёрын ялгаа юу вэ?

Зарим эмнэлгүүд **ариутгал** гэдэг нэрийг хэрэглэж байхад, зарим нь **халдваргүйжүүлэлт** гэдэг нэрийг хэрэглэдэг. Ариутгал болон халдваргүйжүүлэлт нь нэг ижил зүйл биш бөгөөд олон хүмүүс үүнийг сольж хэрэглэдэг.

Ариутгал гэдэг нь ямар нэгэн зүйлээс бүх нянг устгана гэсэн үг. Үүнийг хийх нь маш хэцүү.

Халдваргүйжүүлэлт гэдэг нь нянгуудыг хангалттай хэмжээнд устган ойр орчинд тархахаас урьдчилан сэргийлнэ гэсэн үг.

Ариутгалын тухай ярихдаа ихэвчлэн эмнэлгийн төхөөрөмж, багажийг дахин хэрэглэхийн тулд нянгаас салгах ажлыг хэлдэг.

Халдваргүйжүүлэлтийг ярихдаа эмнэлгийн шалыг угааж, эмнэлгийн тавилга хэрэгслийг халдваргүйжүүлэн цэвэрлэхийг хэлдэг. Гэхдээ халдваргүйжүүлэлтийн хэд хэдэн үе шат байдаг.

Энэхүү номонд заасан **дээд зэргийн халдваргүйжүүлэлт** гэдэг үг нь бүх нянгуудыг устгана гэсэн үг юм. Ийм учраас хог хаягдлын хувьд бид халдваргүйжүүлэлт гэсэн ойлголтыг хэрэглэж байна.

Ямар хог хаягдлыг халдваргүйжүүлэх шаардлагатай вэ?

Цус, биеийн шингэн буюу өтгөн ялгадас, эсвэл халдварт өвчтэй хүнд хүрсэн аливаа материал, тоног төхөөрөмж бүхнийг халдвар тараахаас урьдчилан сэргийлж халдваргүйжүүлэх ёстой.



Халдваргүйжүүлэх шаардлагатай хог хаягдлууд:

- Хэрэглэсэн тариурууд болон бусад хурц үзүүртэй багажууд.
- Цус ба бусад биеийн шингэн.
- Боолт, шархны лент болон бусад биеийн шингэнийг шингээсэн хог хаягдал.



- Цус, биеийн шингэн болон өтгөн ялгадаснаас бохирдсон бусад зүйлс.
- Холери гэн мэт халдварт өвчнөөр өвчилсөн хүний өтгөн ялгадас.
- Өвчтөнүүдийн ор ба орны хэрэгслүүд.

Халдваргүйжүүлэх шаардлагагүй хог хаягдал:



- Хүний биеийн гаралтай хаягдал /төрсний дараа гардаг эхэс, хүүхдийн цөглөсөн хүй зэрэг/.
- Ариутгал цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус.
- Ариутгал цэвэрлэгээний болон лабораторийн шинжилгээний химийн бодис.
- Хоолны хаягдал.
- Цус болон биеийн шингэнд өртөөгүй аливаа бусад материал /цаас, картон, хуванцар, шил, металл/.



Химийн бодисоор халдваргүйжүүлэх

Халдваргүйжүүлэлт хийхэд ашигладаг химийн бодисууд орчинд аюултай байж болох учир түүнтэй маш болгоомжтой ажиллах хэрэгтэй. Халдваргүйжүүлэлтэд өргөнөөр ашигладаг бодисууд нь 6%-ийн устөрөгчийн пироксид, 70%-ийн хлорины уусмал, 70-90%-ийн спирт юм.

Нийтлэг хэрэглээний цэвэрлэгээ ариутгалын олон бодисууд нь глутаралдегид /glutaraldehyde/ буюу формалдегид /formaldehyde/ юм. Энэ хоёр бодисыг ойр ойрхон амьсгалвал хорт хавдар болон үхэлд хүрэх аюултай. Тиймээс эдгээр бодис орсон халдваргүйжүүлэгчийг ашиглахгүй байх нь дээр. /

Химийн бодисыг ашиглан аюулгүй аргаар ариутгал хийх болон химийн бодисуудыг хэрхэн аюулгүй хаях тухай 438, 448, 446-р хуудсыг үзнэ үү/

Олон эрүүл мэндийн төвүүд химийн бодисыг ашиглахдаа дараах аюулгүй байдлын журмыг сахидаг:

- Химийн халдваргүйжүүлэгч бодисыг гадаа буюу, эсвэл маш сайн агааржуулагчтай өрөөнд сэнс ажиллуулж хэрэглэнэ.
- Ажил хийхэд шаардлагатай хэмжээнээс илүү химийн бодис хэрэглэхгүй.
- Химийн бодистой харьцаж байх үедээ бээлий өмсөж, нүдний шил, маск зүүж, хамгаалалтын хувцас өмсөж, ил харагдах арьс үлдээлгүй бүрэн хамгаална.
- Халдваргүйжүүлэлтэд хэрэглэх химийн бодисуудыг зохих ёсны саванд нь хадгална. Савнуудыг хаягжуулна. Тэдгээр савнуудыг өөр юунд ч дахин ашиглаж болохгүй.
- Химийн бодисуудыг болон тэдгээрийн уусмалуудыг усны саванд хийж болохгүй. Мөн эдгээр химийн бодисуудыг хоол ундны сав болон хоол унд, усанд дахин ашиглаж болзошгүй саванд хийж, найруулж, хадгалж болохгүй
- Химийн бодистой савуудыг сайн таглаж, босоогоор нь зөв хадгална. Саванд цоорхой цуурхай гарч, гоожиж байгаа эсэхийг шалгана.



Химийн халдваргүйжүүлэлт шаардлагагүй хог хаягдал

Хүмүүс ихэнхдээ хүний биеийн гаралтай хогийг халдваргүйжүүлэх шаардлагатай гэж үздэг. Гэхдээ төрсний дараа гардаг эхэс, хүүхдийн цөглөсөн хүй зэрэг нь газар булаах буюу жорлонд хийхэд л хангалттай байдаг. Гэхдээ олон орон нутагт хүний эхэсийг ёс журамтай тусгай ёслолоор булдаг. Үүнийг аюулгүй хийж чадвал эхэсийг булснаар орон нутагт янз бүрийн нян үржиж гарч ирэхээс хамгаална. /Хогийг аюулгүй булаах аргуудын талаар 442-446-р хуудаснаас үзнэ үү/

Аюул багатай химийн бодисоор халдваргүйжүүлэлт хийх

Зарим эмнэлгүүд аюултай химийн бодис агуулсан хүчтэй химийн хорнуудыг авч ариутгал, халдваргүйжүүлэлт хийдэг. Гэтэл эмнэлгийн шал, ширээ зэрэг гадаргуунууд нь нянгүй байхын тулд бага аюултай, хямд үнэтэй цэвэрлэх бодисоор цэвэрлэхэд хангалттай байдаг.

Өдөр тутмын цэвэрлэгээнд халуун ус, саван үр дүн сайтай байдаг. Хана, шал, тавилгыг түүгээр цэвэрлэдэг.

Харин халдварт өвчтэй хүн хэвтэж байгаа газар өвчнийг тараахгүйн тулд арай хүчтэй цэвэрлэгээ хэрэгтэй. Жүржийн тос болон бусад байгалийн тосны орцтой устөрөгчийн пироксидын уусмал нь шал болон бусад гадаргууг халдваргүйжүүлэхэд сайн үр нөлөөтэй. Тэдгээр нь эрүүл мэндийн асуудлыг үүсгэдэггүй бөгөөд түүний хаягдлыг ариутгаж халдваргүйжүүлэх шаардлагагүйгээр жирийн байдлаар хаяж болно.

Аюулгүй халдваргүйжүүлэлтийн уусмалуудыг венигер болон устөрөгчийн пироксид ашиглан хийж болно.

Аюулгүй халдваргүйжүүлэлтийн уусмалыг яаж хийх вэ?

Цагаан венигер болон устөрөгчийн пироксидыг ижил тэнцүү хэмжээгээр холь . Ихэвчлэн 3%-ийн пироксид элбэг байдаг ч 6%-ийнх нь илүү сайн. Энэ бэлдмэлийг хийхдээ тухайн өдөрт хэрэглэх хэмжээгээр хий. Түүнийг тагтай саванд хийж тагла. Шингэнээсээ алчуурныхаа үзүүрт бага зэрэг дусаагаад халдваргүйжүүлэх газраа хүчтэй үрж арч. Энэ холимог нь ширээний тавцан, орны толгой, бусад газруудыг халдваргүйжүүлэхэд тохиромжтой.



Хлорын шохой ашиглан халдваргүйжүүлэх нь

Олон эрүүл мэндийн төвүүд хана, шал болон ширээгээ халдваргүйжүүлэхдээ хлорын шохой ашигладаг. Түүнийг ашиглан халдваргүйжүүлэх үедээ болгоомжтой байх ёстой. Учир нь тэр арьсыг гэмтээж, нүд рүү үсэрч орох буюу эсвэл амьсгалах үед хортой үнэр, хий гаргана. Цагаан венигерийг хлорын шохойтой холих нь ариутгах чадварыг улам хүчтэй болгоно.



Ямар нэгэн бүтээгдэхүүн худалдаж авахын өмнө энэ бүтээгдэхүүн аюултай юу, түүнийг аюулгүй аргаар хаяж устгахад хэцүү юу гэдгийг асууж бай.

5%-ийн хлорын шохойгоор халдваргүйжүүлэх уусмал хэрхэн хийх вэ?

Хэрэв таны хлорын шохойн дээр:	хэрэглэх хэмжээ	хлорын шохой
5% хлорин байвал	зөвхөн хлорын шохой	хлорын шохой
10% хлорин байвал	нэг орц хлорын шохой, нэг орц ус	хлорын шохой + ус
15% хлорин байвал	нэг орц хлорын шохой 2 орц ус	хлорын шохой + ус + ус



Хэрэв та 4 литр орчим 5%-ийн хлорын шохойн уусмал дээр нэг аяга цагаан венигер хэрэглэвэл энэ нь илүү сайн халдваргүйжүүлэгч болно. Хлорын шохойг зөвхөн тухайн өдрийнхөө хэмжээгээр найруул. Маргааш нь дахин бүү хэрэглэ. Яагаад гэвэл уусмал хоносны дараа нянг устгах чадвар муудна. Түүнийг хэрхэн зайлуулах талаар 445-р хуудаснаас үзнэ үү.

Шохойны хувин ашигла

Шархны боолт, тарианы хөвөн, бээлий, цусны уут зэрэг халдвартай хог хаягдлыг халдваргүйжүүлэх үедээ шохойны хувинг хэрэглэж бай. Шохойны хувинг өдөр бүр ээлжинд гарч тухайн өдрийн хог хаягдлыг эхлэхээс өмнө бэлтгэж бай.

Таны шохойны хувин нь хоёр янз байвал зүгээр. Нэг шохойны хувиндаа халдваргүйжүүлэх хог хаягдлыг хийх, нөгөө хувиндаа халдваргүйжүүлэх багаж төхөөрөмжийг хийвэл дээр. Тоног төхөөрөмжийг дахин хэрэглэх тул тусдаа хувинтай байх нь дээр.

Зүсэгдэж муудсан бээлий, тарианы савнууд, дуслын тарианы уут, шил, хоолой болон бусад дахин ашиглахгүй жижиг хог хаягдлуудыг шохойны хувин руу шууд шидэж болно. Шохойны хувинд үргэлж хангалттай хэмжээний уусмал байх ёстой ба уусмал нь дотроо байгаа хог хаягдлыг хучиж, дээгүүр нь илүү гарахуйц байх ёстой.

Хог хаягдлын материалууд уусмал дотор дор хаяж 10 минут байх ёстой. Шохойны хувин асгарахаас урьдчилан сэргийлж сайн таглаатай байлга. Мөн хлорын шохойны уусмалыг халдваргүйжүүлэлт явуулах хэмжээний хүчтэй байлга. Таггүй байлгавал хлорин нь амархан ууршиж алга болно.

Хлорын шохойны хувинг яаж хийх вэ?

Аюулгүй аргаар халдваргүйжүүлэлт явуулах нэг арга зам нь хлорын шохойны хоёр хувин ашиглах явдал юм. Уусмал агуулсан хувин нь дотор талд нь багтах жижиг олон нүхтэй шүүлтүүр хувин, эсвэл хог хаягдлыг тогтоон барих хэмжээний нэхмэл хувин байж болно. Шохойны хувин нь сайн тагтай байх ёстой.

Хлорын шохойны хувинг бэлтгэхдээ: 5%-ийн хлорын шохойны уусмалыг хий. Гол хувиндаа дор хаяж тал дундуур хэмжээтэй шохойны уусмалыг хий. Дээр нь жижиг шүүрэн хувингаа тогтоо. Түүний нүхнүүдээр шохойны уусмал нэвтрэн орж ирнэ. Дотор талын хувинг хөвүүлэхгүйгээр сайн тогтоо. Ингэвэл хлорын шохойны уусмал нь дотор талын хогны хувинд хангалттай нэвтрэн орж материалыг бүрхэж сайн ариутгана.



ЧУХАЛ САНАМЖ: Хлорын шохойны уусмалыг бусад химийн бодистой хэзээ ч хольж болохгүй. Ялангуяа аммиактай хольж огт болохгүй. Хэрэв тэгвэл маш хортой хий гарч түүнийг амьсгалсан хүн үхэх магадлалтай. Мөн энэ хоёр бодис нийлвэл халж тэсрэлт үүсгэдэг. Хлорын шохойтой ажилласны дараа заавал гараа сайн угааж бай.

Угаалга хийх

Хуучны цагт олон эмнэлгүүд орны даавуунуудаа ариутгахын тулд карболийн хүчлийг ашигладаг байжээ. Энэ нь түлэгдэлтээ эмчлүүлж байгаа өвчтөнүүдийн хувьд зайлшгүй шаардлагатай юм. Орны даавуу, хувцсыг халдваргүйжүүлэхийн тулд түүнийг хлорын шохойны хувинд 10 минут дүрж дэвтээгээд дараа нь халуун усаар савандаж угаахад хангалттай. Тэднийг хлорын шохойны уусмалаас гарган авахдаа бээлий өмсөх хэрэгтэй.

Дулаанаар халдваргүйжүүлэх нь

Олон эрүүл мэндийн төвүүд халуун тогоо буюу микрочайр ашиглан тариур болон бусад эмнэлгийн багаж хэрэгслийг, мөн зарим хог хаягдлыг ариутгадаг. Хэрэв танайд халуун тогоо юм уу микрочайр байхгүй бол буцалгах, ууранд тавих буюу даралттай уураар 20 минут орчим халаах зэргээр халдваргүйжүүлэлт хийх боломжтой. Халдваргүйжүүлэх хог хаягдлыг эмнэлгийн дахин хэрэглэх багажтай хамт хийж болохгүй. Эдгээр нь тусдаа цэвэрхэн халдваргүйжүүлэх ёстой.

Шээс, цусны катетар, дуслын шингэний уут, шланк, том шархны боодол болон бусад жижиг хэрэгслүүдийг хайчилж зүсэхийн өмнө бээлий өмсөж маск зүүх хэрэгтэй.

Хэрхэн халдваргүйжүүлэх вэ?

Буцалгаж, даралттай ууранд халааж байгаа үед усыг бүрэн буцалж эхэлснээс хойш 20 минут байлга. Хугацааг тооцож эхэлснээс хойш шинэ зүйлийг саванд бүү хий. 20 минутын дараа халаалтыг унтрааж аажим хөргө.

Дахин хэрэглэх материалуудыг буцалсан юм уу ууранд хийсэн савнаас ариутгасан бээлий, эсвэл ариутгасан чимхүүрээр авах хэрэгтэй. Ингээд халдваргүйжүүлсэн саванд шууд хийж таглана. Буцалсан усыг усны хоолой руу шууд асгаж болно.



Буцалгах

Металл, резин, хуванцар багаж болон хувцас даавуун материалуудыг буцалгаж халдваргүйжүүлж болно. Багаж материалуудыг угааж зайлсныхаа дараа саванд хийж багажийг далд ортол нь ус нэмж, усыг буцалснаас нь хойш 20 минут үргэжлүүлэн буцалгана.



Ууранд ариутгах

Бээлий, маск болон металл хуванцраар хийсэн зүйлүүд зэргийг ууранд ариутгаж болно. Ууранд ариутгаж байх үед саванд материалуудыг давсан ус байх албагүй. Гэхдээ ууранд нь 20 минут байж болохуйц ус хийсэн байх ёстой. Уурыг гаргаж байгаа сав нь сайн таглаатай байх ёстой.




Даралтат уурын саванд ариутгах

Металл, резин, пластик болон даавуун материалыг даралтат уурын сав ашиглан ариутгаж болно. Түүнд материалыг хийхээс өмнө угааж зайлсан байх ёстой. Савандаа ус хийж материалуудыг хийж зуухан дээр халаа. Буцалж эхэлснээс хойш даралтан дор 20 минут буцална.

Автоклав

Автоклав гэдэг нь халуун, даралт хоёрыг ашиглан материалуудыг ариутгадаг жижиг машин юм. Олон жилийн турш эмнэлгийн багажийг ариутгахад үүнийг ашиглаж иржээ. Сүүлийн үед автоклав ашиглан хогийг ч бас халдваргүйжүүлж байна. Дахин хэрэглэх хог, багаж хоёрыг хоёр өөр машин ашиглан ариутгах хэрэгтэй.

Харин маш бага хаягдал гардаг жижиг эмнэлэгт хог хаягдлыг ариутгахад даралтат сав ашиглах нь автоклаваас хямд байна. Цахилгаангүй газарт хий, керосин, нараар ажилладаг автоклав ашиглаж болно.



Микрочайр


Микрочайр нь дотор нь халааж байгаа материалын чийгийг халаадаг. Тэр халалт нь микрочайр дотор байгаа хугацаатай нийлж халдваргүйжүүлэлт явуулна. Микрочайрүүд нь хүчин чадлаараа ялгаатай байдаг учраас хүчин чадлыг нь харж хэрэглээрэй.

Өндөр түвшний халдваргүйжүүлэлт хийхийн тулд:

1. Металл биш хог хаягдлыг усаар хангалттай бүтээгээд микрочайринд тавь.
2. Савтай материалынхаа дээр халаалтаас ус алдахуйц байдлаар сул таг тавь.
3. Хог хаягдлын материалыг 20 минут халаа.
4. Халдваргүйжүүлсэн материалыг гаргахын өмнө савыг хөртөл нь хүлээ.

Микрочайрнд халсан шингэн хаягдлыг газраар шүүрч ногооны талбай руу орох чийглэг нүхэнд хийж болно. Эсвэл усны суваг руу асгаж болно.

ЧУХАЛ САНАМЖ: Микрочайринд металл зүйл хийж огт болохгүй, энэ нь машиныг эвдэлдэг.



Халдваргүйжүүлэлтийн дараа

Ямар төрлийн халдваргүйжүүлэлт явуулснаас үл хамааран халдваргүйжүүлэгдсэн хог хаягдлыг халдваргүйжүүлэлт явуулсны дараахан уутанд хийж хаях ёстой. Хог хаягдлыг өвчтөнүүдээс хол байлгаж, халдвартай бусад хаягдалтай холихгүйгээр зайлуулах ёстой.

Хурц үзүүртэй хог хаягдалтай харьцах

Эрүүл мэндийн хог хаягдлаас гардаг олон аюул нь хурц үзүүртэй хог хаягдлаас болдог. Зүү, хутганы үзүүр, бритва болон шарх, халдварт өртсөн олон хурц үзүүртэй материалуудыг маш болгоомжтой хаях ёстой.

Эрүүл мэндийн төвүүдийн гадуур хог болон хоёрдогч түүхий эд цуглуулдаг хүмүүст хурц үзүүртэй материалууд шууд аюул заналхийлэл учруулна. Тэдгээр хогийг багасгахын тулд зөвхөн шаардлагатай үед л тариа хийж байх ёстой.

Тариурын зүү болон бусад хурц зүйлийг аюулгүйгээр хаях

Тариа хийсний дараа тариурын зүүг тарианы бүлүүрээс салгаж, зүүний хаягдлыг хадгалах хайрцагт шууд хийх ёстой. Зүүндээ зүүний тагийг буцааж углах нь аюултай ба хэрэггүй зүйл байдаг. Дахин хэрэглэдэг зүү хэрэглээгүй бол нэг удаагийн зүүг шууд хаях хэрэгтэй. Зүүг тариураас аюулгүй байдлаар сугалдаг олон янзын арга байдаг. Ямар ч аргаар сугаллаа гэсэн доорх зүйлийг анхаар:

- Зүүнд хатгуулахгүйн тулд зөвхөн ганц гараараа ажилла.
- Зүүг хатуу хайрцаг руу хая.
- Зүүг хаях хайрцаг нь хэрэглэхэд эвтэйхэн байх ёстой.




Хурц үзүүртэй хаягдлыг хаях нүхтэй хайрцгийг яаж хийх вэ?

Нүхтэй хайрцаг гэдэг нь нэг талдаа арай өргөн нөгөө талдаа нарийхан урт гонзгой зураасан хэлбэртэй металл хайрцаг юм. Та ийм хайрцгийг худалдан авах буюу металлын засварчин хүнээр хийлгэж болно. Түүнийг бас кофены лааз болон бусад лаазаар хийж болно. Ийм хайрцагны ач холбогдол нь таныг тариурын зүүнд хүрэхгүйгээр зүүг сугалахад тусална.

1 Тариурыг хэрэглэж дуусангуут зүүг доош харуулаад хайрцагны нарийхан үзүүр рүү нь гулгуул.

2 Дараа нь тариурынхаа бүлүүрийг татан зүүг сугал. Зүү хайрцаг руу шууд унана. Тариурынхаа бүлүүрийг хогийн саванд хий.

3 Хурц үзүүртэй хог хаягдлын хайрцаг 3/4 хүртлээ дүүрсэн үед түүнийг хурц үзүүртэй хаягдал хаядаг нүх рүү хая. Эсвэл хурц үзүүртэй зүйлүүд хийдэг хогийн сав руу хая. /хурц үзүүртэй хог хаягдлыг хэрхэн аюулгүй хаях талаар 445-р хуудаснаас үзнэ үү/



Тариурын нэр төрлүүд

Дахин ашигладаг тариур: гэдэг нь дахин дахин ашиглаж болдог тариур юм. Дахин ашигладаг тариур нь бага хог хаягдал гаргаж, мөнгө хэмнэдэг бөгөөд гэхдээ түүнийг маш сайн угаан халдваргүйжүүлэх ёстой. Түүнийг халдваргүйжүүлэхгүйгээр хэзээ ч ашиглаж болохгүй. Хэрэв ингээгүй бол ДОХ, элэгний гепатит болон бусад өвчний нян түүгээр халдварлан дамжина.

Нэг удаагийн тариур: үүнийг ганц удаа хэрэглээд хаях ёстой. Зарим үед нэг удаагийн тариурыг салган угааж, буцалгаж, ууранд хадгалж, хэд хэдэн удаа ашиглах тохиолдол гардаг.

Ингэх нь зохимжгүй юм. Яагаад гэвэл нэг удаагийн тариур болон зүүг бүрэн халдваргүйжүүлэх боломжгүй.

Автоматаар ажиллахгүй болдог тариур: энэ тариур нэг удаа хэрэглэсний дараа зүү нь бөглөрөх юм уу түгжигдэж, дахин ашиглах боломжгүй болдог. Гэхдээ автоматаар хаагддаг тариурын зүү нь дотроо хэвээр байдаг учраас хүн рүү хатгах аюултай. Энэ тариурыг аюулгүй хаях аргыг 444-445-р хуудаснаас үзнэ үү.

ЧУХАЛ САНАМЖ: тариур болон тариурын зүүг урьдчилж цэвэрлэж халдваргүйжүүлэхгүйгээр хэзээ ч бүү ашигла.

Дахин ашиглах тариур болон зүүг хэрхэн угааж ариутгах вэ?

Тариурыг сайн цэвэрлэж ариутгахгүй бол ДОХ болон бусад өвчин тархдаг учир сайтар ариутгаж чадахгүй үедээ тариурыг дахин хэрэглэхгүй байх хэрэгтэй. Зарим орон нутагт тариур хангалттай олон байдаггүй учраас тэд нэг удаагийн тариурыг хаядаггүй. Тэд аль болохоор тариурын зүү, тариурыг олон удаа хэрэглэхээс аргагүй байдаг. Иймээс тариурын зүү, тариаг хэрхэн ариутгах зааврыг энэ номонд орууллаа.


1 Гартаа нянгийн халдвар авахаас урьдчилан сэргийлж зузаан хос бээлий өмс.

2 5 %-ийн хлорын шохойн уусмалыг зүүгээрээ соруулан ав. /хлорын шохойн уусмал хэрхэн хийхийг 437-р хуудаснаас үз/

3 Шохойн уусмалыг зүүгээрээ шахан гарга.

4 Энэ үйлдлийг хэд дахин давт. Дараа нь хэд хэдэн удаа цэвэр ус соруулан мөн зайл.






5 Зүү тариуруудыг салгаж аваад усанд буцалгах буюу ууранд ариутга. /438-р хуудсыг үз/



Халдвартай хог хаягдлыг хаях

Доорх хүснэгтээр халдвартай хог хаягдлыг жижиг эмнэлэгт хэрхэн хаяж болохыг үзүүлээ. Зарим эмнэлгүүд энэ аргыг бүгдийг нь хэрэглэж чадахгүй байж болно. Эсвэл үүнээс сайн аргыг өөрсдөө хэрэгжүүлж байж болно. Халдвараас сэргийлэх хамгийн сайн арга нь халдвараас хамгаалах системийг эмнэлэгт ажиллаж байгаа хүн бүхэнд ойлгомжтой байхаар зохион байгуулах ёстой юм. Асуудлын чухлыг ойлгож байгаа хүмүүс л түүнийг даган биелүүлнэ.


ЧУХАЛ САНАМЖ: эрүүл мэндийн хог хаягдлаас хэрхэн салах талаар хууль журмыг дага.

Нэр төрлөөр нь ялга	ХУРЦ ҮЗҮҮРТЭЙ /зүү хутга, бритва, хагархай шил болон бусад хурц зүйлс/	ЦУС БҮЮУ БИЕЙН ШИНГЭНЭЭР БОХИРДСОН ЗҮЙЛС /цусны уут, диалезийн материал, тарианы бүлүүр, бээлий, маск, шархны боолт, хөвөнгийн шаариг, боолт, бусад хог/	ЦУС БИЕЙН ШИНГЭН БОЛОН ӨТГӨН ЯЛГАДАС /шингэн цус, биеэс соруулж авсан шингэн өтгөн ялгадас болон бусад биеийн ялгадас/	БИЕЙН ХЭСЭГ /гайрсан хөл, арьс, хуулсан шарх зэрэг/
Тус тусад нь өөр өнгийн сав хэрэглэ.	 Хурц үзүүртэй хог хаягдлыг хаях сав	 Эсвэл  өнгөөр ялгасан хувин, уутны амыг сайн бөглөж тавих. Болгоомжтой зүсч жижиглэсэн хог хаягдлыг хлорын шохойны хувинд хийнэ	 Хогийг шууд хаях хувин	 өнгөтэй уут буюу сав
Савнуудыг хааж бэхэл	Савыг 3/4 хэмжээнд хүртэл дүүрвэл скочоор нааж тагла.	Уут савыг 3/4 хэмжээнд дүүрвэл амыг уяж хаа. Хлорын шохойтой хувинг сайн таардаг тагаар таглаж тавина.	Уут савыг сайн таардаг таглаагаар таглана.	Уутыг 3/4 хэмжээнд дүүрэхэд амыг хааж уяна.
Халдваргүй-жүүлэлт буюу аюулгүй булах	Хурц үзүүртэй хог цуглуулах нүхэнд хийх Хурц үзүүртэй хогны контейнер буюу хайрцагт хийх	Халуун аргаар халдваргүйжүүлэх Хлорын шохойтой хувинд 10 минут байлгаж дараа нь шүүж авах	Хамгаалалтын хувцас өмсөж хлорын шохойтой саванд хийж 10 минут байлгана.	Найдвартай булах нүхэнд хийж дээрээс нь шохой нэмж цацан шороогоор булна.
Эцэслэн хаях	Барэг дүүрсэн үед нь нүхийг цементээр бүтээж таглана. 3/4 хэмжээнд дүүрсэн үед хайрцгийг газарт булан цементээр таглаж хогийн цэг дээр булж хаяна.	Найдвартай хогийн нүхэнд хийж шороогоор булна. Хэрэв нүх бараг дүүрэн бол шороогоор булж бетон зуурч таглана. Хатааж дахин ашиглах буюу шил металл хуванцрыг хоёрдогч түүхий эд болгон хэрэглэнэ. Эсвэл бусад хатуу хог хаягдалтай хамт хаяна.	Шингэн хаягдлыг газраар шүүдэг систем рүү хийх буюу эсвэл ус цэвэрлэх сав, угаалгын суваг руу хийнэ.	Нүх бараг дүүрсэн үед түүнийг шороогоор булж дээр нь бетон зуурч таглана.
Нэмэлт мэдээлэл авах	434-435, 439-р хуудсуудыг үз	429-433-р хуудсыг үз	428, 439-р хуудсыг үз	428, 439-р хуудсыг үз

Вакцинжуулалтын хөтөлбөрүүд

Дэлхий даяар олон сая хүмүүс янз бүрийн өвчний вакцинийг хийлгэж вакцинжуулалтын хөтөлбөрт багтдаг. **Вакцинжуулалтын хөтөлбөрийг** олон улсын эрүүл мэндийн байгууллага болох Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ЮНИСЕФ болон засгийн газартай хамтран, эсвэл вакцин үйлдвэрлэдэг байгууллагууд хамтран хэрэгжүүлдэг.


Эдгээр хүмүүс ихэвчлэн хог хаягдлаа яах талаар тодорхой ажил хийдэггүй. Ихэнх тохиолдолд тэд хогоо вакцинжуулалт хийсэн газраа орхиод явдаг. Үүнээс болж хүмүүс хогийг ил шатааж өөрийнхөө ойр орчинд эрүүл мэндийн шинэ асуудлыг үүсгэдэг.



Вакцинжуулалтын хөтөлбөрүүд хог хаягдлынхаа хариуцлагыг өөрсдөө хүлээх боломжтой

Тодорхой төлөвлөгөө дэмжлэгтэйгээр эдгээр хөтөлбөрүүд доорх аргаар хог хаягдал үүсгэхгүй байж болно.

- Вакциныг ачиж ирсэн машинаараа түүнээс үүсэх хогийг ачиж авах. Хэрэв энэ нь бүс нутгийн хөтөлбөр бол нийт хаягдлаа халдваргүйжүүлэн найдвартай булж болно.
- Орон нутагт эрүүл мэндийн хогийг хаях систем байгуулахад нь туслах. Ингэснээр вакцинжуулалт болсны дараа орон нутгийнхан эрүүл мэндийн хаягдлаа тодорхой журмаар хаядаг болох.
- Вакциныг буудах аргаар өгдөг шинэ технологийг хэрэгжүүлэх. Ингэснээр тариур буюу зүү ашиглах шаардлагагүй болгох.



Эрүүл мэндийн хог хаягдлыг булах

Хурц үзүүртэй хог хаягдал, биеийн хэсгүүд болон хугацаа нь дууссан эмийг хаяхад хогны нүх байх шаардлагатай. Хогны нүхийг ялзмаг болж болох, дахин ашиглаж болох материалуудаар бүү дүүргэ. Мөн халдваргүйжүүлэлт явагдсаны дараа хогийн өөр цэгт хаяж болох материалуудыг бүү хий.

Хэрэв ойр хавьд нийтийн хогийн цэг байдаг бол халдваргүйжүүлсэн хогийг тэнд хаяж болно. Хэрэв тийм цэг байхгүй бол халдваргүйжүүлсэн хогийг хаях тусгай том хогийн цэг байгуулж болно.


Харин хурц үзүүртэй хог хаягдлууд нь хамгийн аюултай хог учраас түүнийг заавал эмнэлгийн ойролцоо найдвартай нүхэнд хаях ёстой. Хог хаягдлыг булахдаа хог хаягдлын менежментийн талаар бүх хүнд ойлголт өгч хийх нь энэ хөтөлбөрийг амжилттай болгоно.

Хогийг найдвартай булах нүх

Хогны нүх нь найдвартай байхын тулд энэ нь орчныг усаар хангадаг худгаас газрын дор байрлаж, гүний уснаас хол байх ёстой.

Гол горхи, болон булгийн эхээс 50 м-ээс доошгүй зайд, гүний уснаас мөн тийм зайд дээшээ байх ёстой.

Нүхний ёроол болон ханыг керамик шавраар нааж эмжин, нойтон зүйл нэвтэрч орохоос хамгаална. Хогны нүхэн дээр тодорхой таних тэмдэг тавьж, эргэн тойронд нь амьтан орохооргүй хашаа байгуулна.



Хогийн нүхийг ухахдаа 50 м-ийн дүрмийг баримтал.


Бетонон таглаатай хогны нүхийг хэрхэн хийх вэ?

- 1 Энэхүү нүх нь халдварт болон аюултай хог хаягдалд тохиромжтой бөгөөд жирийн хогонд зориулагдаагүй болно.
- 2 1-2 м-ийн өргөнтэй 2-5 м-ийн гүнтэй нүх ух. Нүхний ёроол нь гүний уснаас дор хаяж 1,5 м-ийн дээр байна.
- 3 Нүхний ёроолыг 30 см зузаан силикат шавраар шав.
- 4 Нүхний амсар дээр шороо, чулуу юм уу, шавраар овойлгон гадагшаа налсан зах ирмэг хий. Энэ хөрсний ус нэвтрэхээс хамгаална.
- 5 Нүхний эргэн тойронд хашаа барьж хүүхэд болон амьтныг хол байлга. Хогийг нүхэнд хаях бүртээ тухайн хогийг 10 см орчим шороогоор цацаж бай. Заримдаа шороондоо шохой хольж бай. Шохой нь хогийг халдваргүйжүүлэхэд тусалж, бас амьтдыг үргээнэ. Мөн хог нь газрын хөрснөөс хагас метрийн өндөрт хүртэл тулж овойж ирвэл түүнийг хагас метр зузаан шороогоор булж 10-30 см зузаан бетоноор хучиж бүрэн тагла.



Хурц үзүүртэй хог хаягдлуудыг хадгалдаг савыг хэрхэн цементээр таглах вэ?

Хурц үзүүртэй хог хаягдлуудыг хатуу хайрцаг буюу металл бочект хийж хаядаг. Бочекны талбай нь дүүрээд ирэхийн үед түүн дээр нэг орц цемент, нэг орц шохой, дөрвөн орц элс болон 1/3-1/2 орц бүхий устай холимог зуурмагийг хийж орхи. Шохой нь халдваргүйжүүлэгчийн үүрэг гүйцэтгэнэ. Мөн энэ нь цементийг хоосон зайнууд руу чигжиж орон хурц үзүүртэй хог хаягдлыг бүрхэж авахад нь туслана. Зуурмагаар дүүргэсэн бочекийг таглаад түүнийг хогийн цэг дээр буюу хогийн нүхэнд хаяна.



Шингэн хог хаягдлыг хаях


Эрүүл мэндийн төвүүдэд шохойны уусмал, бохир ус болон бусад шингэн хог хаягдлаа бохир усны шугам руугаа хийдэг. Энэ нь тухайн эмнэлгийн бохир усны шугам дараа нь цэвэр усны эх сурвалж руу орохгүй тохиолдолд л аюулгүй байдаг. Хэрэв тэр ус нь явсаар аль нэг гол руу ордог бол аюул учруулна.

Эмнэлэгт гарч байгаа шингэн хог хаягдлыг хаяхын өмнө түүн дээр маш их хэмжээний ус хийж шингэлж бай. Усны эх сурвалжийг хамгаалахын тулд шохойн уусмал болон бусад шингэнүүдийг аюулгүй шүүрэгч нүх рүү хийх нь илүү дээр байдаг.

Glutaraldehyde and formaldehyde шингэнүүдийг хаяхын өмнө саармагжуулах хэрэгтэй байдаг.

Аюулгүй шүүрүүлэх нүх байгуулах

Үер болдоггүй газруудад болон усны эх сурвалжаас хол газруудад хагас метрээс нэг метр хүртэл гүнтэй нүх ухна. Нүхний ёроолд хэдэн см зузаан элс тавина. Дараа нь нэг давхрага, мөн хэдэн см зузаан жижиг чулуун хайрга тавина. Түүний дээрээс нэлээн олон давхар чулуунууд тавина. Нүхний амсрыг борооны ус орохоос хамгаалж таглана.



Химийн хог хаягдлыг аюулгүй аргаар хаях

Ихэнх эрүүл мэндийн төвүүд жижиг томоосоо үл хамааран химийн хог хаягдлыг гаргадаг бөгөөд түүнийг аюулгүй хаях хэрэгтэй байдаг. Том эрүүл мэндийн төвүүд рентгений хаягдал ихтэй, мөн химийн эмчилгээ, лабораторийн хаягдал гаргадаг. Эдгээр хаягдал нь арчилахад төвөгтэй нарийн ажиллагаа шаарддаг тул энэ номонд ороогүй болно. Бид хамгийн энгийн аргуудыг оруулж байна.

Цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтэд ашигладаг химийн бодис

Хлорын шохойн уусмалыг усаар шингэлээд дараа нь аюулгүй шүүрүүлэх нүх рүү асгаж болно. Устөрөгчийн пироксидийн уусмалыг ямар нэгэн нэмэлт ажиллагаагүйгээр асгаж болно. Түүнийг бохир усны шугам руу юм уу жорлон руу чөлөөтэй асгаж болдог.

Glutaraldehyde and formaldehyde нь хорт хавдар үүсгэж үхэлд хүргэж болдог. Гэлээ ч эмнэлгүүд энэ бодисыг ариутгалд, халдваргүйжүүлэлт болон цэвэрлэгээнд хэрэглэдэг. Тэднээс аюулгүй салах арга бий.

Glutaraldehyde and formaldehyde-ийг хаяхын өмнө түүн дээр каустик буюу эхүүн содийг нэмж, дээрх хоёр бодисын хүчиллэгийг өөрчлөх ёстой.

Бодисуудын хүчиллэгийг хэмжихдээ рН метрээр юм уу лакмус цаасаар хэмжиж болно.

- рН-ийг 12 хүртэл нь болгоод тухайн рН дээр нь дор хаяж 8 цаг байлга.

- Дараа нь рН-ийг саармаг буюу 7 гэсэн хэмжээнд авчрахын тулд HCl буюу устөрөгч хлорын хүчлийг нэм.

- Хэрэв та Glutaraldehyde and formaldehyde-ийг аюулгүй хаях хэмжээний хэрэгсэл материал байхгүй бол тэдгээрийг битгий хэрэглэ.

- Тэднийг аюулгүй хаяж чадахгүй бол орчин болон танд аюултай.

- Харин аюулгүй болгон саармагжуулсны дараа аюулгүй шүүрүүлэх нүх рүү асгаж болно.

Орны даавууг ариутгахад ашигладаг карболийн хүчил нь амьсгалаар болон арьсаар дамжин эмгэг үүсгэдэг. Иймээс дээрх хүчлээр ариутгал хийж байгаа ажилчин нүдний шил, маск зүүж, бээлий өмсөх ёстой. Түүнээс гарсан хаягдал усыг содын гидроксидийн уусмал руу хийгээд дараа нь аюулгүй шүүрүүлэх нүхэнд хийх ёстой.



Шингэн химийн хог хаягдлыг бэлдэж байх үедээ хамгаалах хувцас өмсөж тэдгээрийг цалиглуулахаас болгоомжил.

Мөнгөн ус

Мөнгөн ус нь халууны шил дотор байдаг мөнгөлөг шингэн юм. Түүнийг цусны даралтын аппарат, батарей, чийдэн болон олон зүйлд хэрэглэдэг. Мөнгөн ус нь маш хортой хүнд металл юм. Түүнийг арьс буюу амьсгалаараа өчүүхэн бага хэмжээгээр шингээж авсан байсан ч тэр хүний мэдрэл, бөөр, уушиг, уураг тархинд нөлөөлөх ба төрөлхийн гажигтай хүүхэд төрүүлдэг.

Мөнгөн ус шатааснаар түүнийг устгаж чадахгүй харин улам аюултай хий гардаг. Мөнгөн усны аюулыг багасгах хамгийн сайн арга зам нь мөнгөн устай багаж хэрэгслийг аль болохоор бага хэрэглэх хэрэгтэй.

Мөнгөн устай багаж хэрэгслүүдийг металл дээр тавьж бай. Модон тавцан дээр байж байгаад эвдэрвэл шал, мод руу нэвтэрч ордог. Боломжтой бол мөнгөн ус хэрэглэдэггүй халууны шилийг хэрэглэж бай.



Мөнгөн ус асгарах үед хэрхэн цэвэрлэх вэ?

Халууны шил буюу бусад зүйлээс мөнгөн ус гоожвол мөнгөн ус жижиг жижиг хэсэг болон бутардаг.


Мөнгөн ус асгарсан газраас хүн амьтныг хол байлга.

Бүх төрлийн халаалт, зуух, плитка, агааржуулагч сэнсийг унтрааж, цонх онгойлгон агаар оруул.

Түүний асгарсан хэсгийг цэвэрлэхийн тулд танд бээлий, нүдэнд эм дусаадаг дусаагуур, хоёр ширхэг хатуу кардон цаас, хоёр гялгар уут, мөн скоч, гар чийдэн, устай варений шил хэрэгтэй болно.

Мөнгөн усыг аюулгүй цуглуулахын тулд:


1. Мөнгөн усанд бүү хүр. Хаалга цонхыг онгойлго.
2. Цаг болон үнэт зүүлт, хатуу эдлэлийг тайл. Мөнгөн ус бусад металд очиж наалддаг.
3. Мөнгөн усыг хялбархан олж харахын тулд өдрийн цагаар байсан ч хамаагүй гар чийдэн тусгаж ажилла.
4. Болж өгвөл химийн бодис нэвтэрдэггүй бээлий өмс. Хэрэв танд зөвхөн даавуун бээлий байгаа бол 2 давхар бээлий өмс
5. Жижиг хатуу цаас юм уу кардон ашиглан мөнгөн усыг жижиг жижгээр цуглуул.
6. Нүдний дусаагуур ашиглан мөнгөн усны жижиг шүрнүүдийг соруулж аваад устай варений шил рүү хий.
7. Үлдсэн мөнгөн усны үлдэгдлийг скочинд нааж цуглуул
8. Скочонд наалдсан мөнгөн ус болон скочийг гялгар уутанд хий. Мөн нүдний дусаагуур, бээлий, картон цааснуудыг гялгар уутанд хий.
9. Гялгар уутан дээрээ мөнгөн усны хаягдал гэж бичээд гялгар уутаа устай варений шилэндээ хий.
10. Варений шилийг таглаж хаяглаад түүнийг дахиад нэгэн гялгар уутандаа хий.
11. Үүнийг хортой хог хаягдал хаях журмаар бул /410-р хуудсыг үз/.



Антибиотек болон бусад эм

Хуучин эмүүд нь нэг төрлийн химийн хаягдал бөгөөд түүнийг аюулгүй хаях ёстой. Антибиотек болон бусад эмүүдийг аюулгүй хаяна гэдэг нь түүнийг хог янзалдаг хүнээс болон усны эх сурвалжаас хол хаяна гэсэн үг юм.

Харамсалтай нь, эрүүл мэндийн төвүүд, эмийн сангууд, эмийн компаниуд хуучин эмээ задгай хогийн цэг болон усан сан, бохир усны хоолой руу шууд хаячихдаг. Антибиотек нь байгальд ил хаягдахаараа хүн, амьтан, болон байгальд үүсдэг нянгуудад антибиотект тэсвэртэй байдал үүсгэдэг. Энэ нь өвчин туссан хүн хэрэгтэй үедээ антибиотек уух гэтэл нян нь нэгэнт антибиотект үхэхээ больсон байна гэсэн үг. Ингэж антибиотекийг буруу хаях нь эрүүл мэндэд хохирол учруулдаг юм.



Аль болох бага антибиотек худалдан авч хэрэглэ

Тухайн өвчнийг эдгээж чадахгүй антибиотекийг бүү хэрэглэ. Хэрэв таны эрүүл мэндийн төвийнхөн зөвхөн хэрэгцээтэй хэмжээгээр антибиотек худалдан авдаг бол эмийг хуучирсны дараа их хэмжээгээр хаях шаардлагагүй болно.

Хугацаа нь дууссан эмийг үйлдвэрлэгч рүү нь буцаа

Эмийн компаниуд хугацаа нь дууссан антибиотек болон эмийг аюулгүй хаях төхөөрөмжтэй байдаг. Тэд тийм системтэй байх

ёстой. Хэрэв та хугацаа нь дууссан эмийг буцааж чадахгүй бол аюулгүй хаях аргуудыг хэрэглэ.

Эмийг хэрхэн аюулгүй хаях вэ?

- 1 Бээлий өмсөж, нүдний шил зүүж, тоос шорооноос хамгаалсан маск зүү.
- 2 Эмийг нухаж нунтагла.
- 3 Эмийн нухсан нунтагийг аваад цементтэй хольж хутга.
- 4 Холимог дээрээ ус нэмж цементэн бөмбөлөг үүсгэ.
- 5 Түүнийгээ таглаатай хогийн нүхэнд хая.




Эрүүл мэндийн хог хаягдлын нөхцөл байдлын үнэлгээ хий

Эрүүл мэндийн хог хаягдал яаж бий болж байна? Яаж хаягдаж байна? Яаж цуглуулж байна гэдгийг үнэлж дүгнэх нь эрүүл мэндийн төвд байгаа бүх хүмүүст хог хаягдлаа цаашид зөв хаяхад нь тусална. Хог хаягдлын үнэлгээ нь хог хаягдлыг гаргах, цуглуулах, хаях явцад гарч болох шийдлүүдийг зааж өгнө.

Эрүүл мэндийн хог хаягдлын үнэлгээг хийх алхмууд


1. Эрүүл мэндийн төвийн бүх ажилчдын уулзалт хийж асуудлыг хэлэлц.
2. Эмийн сангийн болон хангамжийн өрөөнд очууц байгааг жагсааж бич.
3. Эрүүл мэндийн төвийн схем ба газрын зургийг гарга.
4. Төв дундуур явган явж асуудлуудыг тэмдэглэж ав.
5. Хог хаягдлыг янзалж хаях энэ дүрийн сонголтуудын талаар суралц.
6. Эмнэлэгт болон орчны оршин суугчид хог хаягдлыг хэрхэн арилж хаяж байгаа талаар мэдээлэл ав.
7. Арга хэмжээ ав. Ямар нэгэн зүйл хий.
8. Ажилчдыг тогтмол сургаж боловсруулж бай.



1 Эрүүл мэндийн төвийн бүх ажилчдын уулзалт хийж асуудлыг ярилц

Эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа хүн бүр үнэлгээ дүгнэлт хийхэд оролцох ёстой. Эмч, сувилагч, хог хаягдал цэвэрлэгч нар бүгд оролцож, өөрсдийн санаа бодлыг хэлж, хог хаанаас гарч ирж байгаа, ямар асуудал байгааг ярилцана.





2 Эмийн сангийн болон хангамжийн өрөөнд ямар материал байгааг жагсаа

Ихэвчлэн материалуудыг эмийн сан болон хангамжийн өрөөнүүдээс авдаг тул тэр өрөөнд юу байгааг бүртгэж эхэлнэ. Тэнд байгаа бүх зүйлийг ажиглаж, үүнээс ямар хог гарч, түүнээс нь ямар аюул учрахыг ажигла. Нэг удаагийн хэрэглээний зүйлийг олон удаагийн хэрэглээний зүйлээр сольж болох уу? Химийн бүтээгдэхүүнийг арай бага хэмжээгээр буюу, эсвэл аюулгүй бүтээгдэхүүнээр сольж болох уу? Эрүүл мэндийн төвийнхөн хуванцар багатай зүйл, мөнгөн ус бага орсон зүйл авч болох уу? Аюултай байдлын хэмжээг багасгах ямар арга хэмжээ авч болохоор байна вэ?

3 Эрүүл мэндийн төвийн схем ба газрын зургийг гарга

Схем зурганд бүх өрөө, хаалга, цонх болон өрөөнүүдийн ашиглалтыг тэмдэглэ. Хог гарч байгаа хэсгүүдийг өнгө ялган буд. Хогийн сав байгаа газар, хог хадгалдаг газар, хог цуглуулдаг, тээвэрлэдэг газрууд болон хогийг эцэслэн булдаг газрыг өнгө ялган тэмдэглэ. Энэхүү схем нь эрүүл мэндийн төв дундуур явган аялал хийх үед өөрчлөгдөж болно. Үнэлгээний ажил дууссаны дараа өөрчлөлтүүдийг тусгасан шинэ газрын зураг гарга. Ингэхдээ хогийн савны байр хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхой тусгах хэрэгтэй.



4 Төв дундуур явган явж асуудлуудыг тэмдэглэж ав

Хог гарч байгаа бүх газруудад оч. Хогийн савуудад үзлэг хийж, тэдгээрт ямар төрлийн хог байгааг тэмдэглэ. Энэ явган үзлэгийн ажлыг өдөрт хэд хэдэн удаа явж, хийж, тэмдэглэ.

Гэхдээ өдөр бүр өөр цагт явж хий. Ингэсний дараа хог ямар нөхцөлд байна, өдрийн турш ямар байдлаар гарч байна, яаж арчилж байгаа нь харагдана. Явган аялал хийхдээ өдөр бүр өөр өөр хүнтэй яв. Мэргэжилтэн бүхэн өөр өөр чухал асуудлуудыг олж харж, чухал санаа гарч ирж болно.



5 Хог хаягдлыг янзалж хаях, янз бүрийн сонголтуудын талаар суралц

Эрүүл мэндийн төв дундуур хэдэн удаа явган аялсны дараа гарсан асуудлыг хэрхэн шийдэж болох талаар бүлгээрээ уулзаж ярилц. Шийдлүүд нь заавал үнэтэй буюу техникийн шийдэл байх албагүй. Ихэнх шийдлүүдэд зохион байгуулалт, хамтын ажиллагаа, хүчин чадал хэрэгтэй байдаг.

Төлөвлөгөөгөө гаргахдаа хамгийн аюултай хаягдал болох хурц үзүүртэй хогийг яахаа бод. Дараа нь химийн хаягдлаа бод. Дараа нь цус ба биеийн шингэн хэсэг гэх зэргээр төлөвлөгөөгөө гарга. Төлөвлөгөөний зорилго нь зөвхөн нэг хоёр зүйлийг өөрчлөх биш бүхэл бүтэн системээ яах вэ гэдэгт оршино.



6 Эмнэлэг болон орчны оршин суугчид хог хаягдлаа хэрхэн арчилж, хаяж байгаа талаар мэдээлэл ав

Хог хаягдал хаана гарч, яаж хадгалагдаж байна, яг хаанаас эмнэлгийг орхин гарч байна, яг хаана хэн яаж цуглуулж авч байна, хогийг тогтмол цуглуулж чадаж байна уу, хог хаягдалтай ажилладаг хүмүүс хамгаалалтын хувцастай байна уу, ямар саванд хийж байна гэдгийг хар.

Хог ялгадаг хүмүүс хэрэгтэй зүйлийг дилерүүдэд зарах дуртай. Энэ нь аюултай юм уу аюулгүй байж болно. Хамгийн гол нь хаяж буй хог нь хэрхэн халдваргүйжүүлэгдсэн, яаж савласнаас хамаарна.

Хог цуглуулж байгаа хүмүүс дахин ашиглах болон хоёрдогч түүхий эдийг хогноос аюулгүй гаргаж чадаж байна уу? Эсвэл энэ ажлыг хялбарчилж, хог зарах ажлыг аюулгүй болгох арга байна уу?

Хог цуглуулж зарж байгаа нь орчны хүн амын эрүүл мэндэд ямар нөлөөтэй байна? Хогон дээр хүмүүст өвчин халдаах, эсвэл хүмүүсийг гэмтээж шархдуулах зүйл байна уу?



7 Арга хэмжээ ав, Ямар нэгэн зүйл хий

Эрүүл мэндийн төвийн ажил орон нутгийн иргэдэд бүгдэд нь нөлөөлөх үед жижиг ч хамаагүй зөв арга хэмжээ авах нь хүмүүст болон орчин тойронд сайнаар нөлөөлнө. Эрүүл мэндийн төв одоо ямар арга хэмжээ авч чадах вэ? Яаж хогоо орчиндоо аюулгүй болгох вэ? Ялангуяа нийтийн хогийн цэг болон шатаах зуух руу явж буй хогийг яаж хамгаалж чадах вэ?

8 Ажилчдыг тогтмол сургаж боловсруулж бай

Ямар ч сайхан аюулгүй байдлын төлөвлөгөө нь уг төлөвлөгөөний ач холбогдлыг мэдэж байгаа эрүүл мэндийн ажилчдын хүчээр хэрэгждэг. Хэрэв хүмүүс мэдлэг боловсролгүй бол хог хаягдлын аюулгүй байдлын систем ажиллаж чадалгүй маргагддаг. Жил бүр хог хаягдлын үзлэг, үнэлгээ, дүгнэлтийг давтан хийх нь хүмүүст болгоомжтой, боловсролтой байхад нь тусална.

Орон нутгийн хамтын шийдэл


Хог цуглуулах, арчлах, хадгалах, тээвэрлэх болон хаяж устгах зарим системүүд нь ганц эрүүл мэндийн төв хүчрэхгүйгээр үнэтэй байдаг. Гэхдээ тухайн газар нутгийн хэд хэдэн эрүүл мэндийн төвүүд хамтрах буюу бүс нутгийн хэмжээнд хамтдаа хог хаягдлын нэг систем рүү орох юм бол амжилтад хүрч болно.

Мөн тэд худалдан авах зүйлсээ хамтдаа уялдуулж, хамтын хүчээр эм болон эмнэлгийн хэрэгслийг нийлүүлдэг компаниудад нөлөөлөн эмнэлэгт нийлүүлдэг аюултай бүтээгдэхүүнийг багасгаж болно.

Мөн хэрэв танай эмнэлэг автоклав болон хогийг аюулгүй хаях нүх байхгүй бол түүнийг ойр орчмын бусад эмнэлгүүдтэй хамтран дундаа халдваргүйжүүлэлт хийдэг газарт хүргэж, дундаа хэрэглэдэг аюултай хаягдлын нүхтэй байж болно. Хурц үзүүртэй хог хаягдлыг эмнэлэг дундаас цуглуулж нэг дор хаядаг зохион байгуулалттай ажил байж бас болно.

Хэрэв хотын хог хаягдлын байгууллага байдаг бол халдваргүйжүүлсэн хог хаягдлыг нийтийн хогийн цэг рүү ачуулж болно. Мөн хотын хортой хог хаягдлын цэг рүү хортой хог хаягдлаа явуулж болно.

Харин орон нутагт хог цуглуулах тогтолцоо байхгүй бол орон нутгийн хатуу хогийг арчлах сайн системтэй болгохын төлөө ажилла. Танай эрүүл мэндийн төвд ямар систем нь илүү зохимжтой байна түүгээрээ ажиллах хэрэгтэй.



Эрүүл мэндийн төвд юу болох нь хүн бүхэнд нөлөөтэй байдаг.